

БНСУ-ЫН ДАНКУУКИЙН ИХ СУРГУУЛЬ

УМАРДЫН СОЁЛЫН ХҮРЭЭЛЭН

МУИС, УЛААНБААТАР СУРГУУЛЬ
НИЙГМИЙН УХААНЫ ФАКУЛЬТЕТ
АРХЕОЛОГИЙН ТЭНХИМ



Монгол-Солонгосын хамтарсан
“Дорнод Монгол ба Умардын Соёл” төслийн
Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт явуулсан
археологийн хээрийн судалгааны ажлын 2010 оны тайлан

Тайлан бичсэн:

Д.Эрдэнэбаатар, Буг Ги де, Т.Идэрхангай, С.Оргилбаяр

Улаанбаатар хот 2010

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН

ШИНЖИЛГЭЭНИЙ АНГИЙН УДИРДАМЖ

Судалгааны ажлын зорилго. Монгол-Солонгосын хамтарсан археологийн хээрийн шинжилгээний анги нь анх 2009 оны 4, 5-р сард Монгол орны зүүн бүсийн нутгаар, тухайлбал Хэнтий, Сүхбаатар аймгуудын нутагт археологийн хайгуул судалгааны ажлыг, 2009 оны 8-р сард Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт шинээр илрүүлэн олсон Вааран хавцал хэмээх газарт археологийн малтлага судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Судалгааны ажлын гол зорилго нь Дорнод Монголын нутгаас шинээр олж илрүүлсэн археологийн дурсгалуудыг судалгааны эргэлтэнд оруулах, улмаар тухайн дурсгалтай нэгэн цаг үед зэрэгцэн оршиж байсан Зүүн хойд Ази болон Солонгосын эртний археологийн дурсгалуудтай харьцуулан үзэж угсаа-соёлын холбоо бий эсэх, цаашлаад угсаа соёлын холбоо хамаарал бий болох шинж тэмдэг олж илрүүлсэн тохиолдолд олон улсын хамтарсан төсөл болгон өргөжүүлэх зэрэг зорилго тавин ажиллаж эхэлсэн билээ.

Судалгааны ажлын бүрэлдэхүүн. Уг хээрийн судалгааны ангийн бүрэлдэхүүнд Монгол, Солонгосын эрдэмтэн судлаачдын баг хамтран ажилласан болно.

Удирдагчид

- | | |
|----------------------------|---|
| - Диймаажавын Эрдэнэбаатар | Монгол улс, Улаанбаатарын Их Сургуулийн профессор, Археологич. НУФ-ын декан |
| - Буг Ги-дэ | Солонгос улс, Боловсролын Удирдлагын Их Сургуулийн профессор, Археологич |

Эрдэм шинжилгээний ажилтнаар

- | | |
|--------------------------|--|
| Төмөр-Очирын Идэрхангай | (Археологич) Улаанбаатарын Их Сургууль, Монгол улс |
| Самданцоодолын Оргилбаяр | (Археологич) Улаанбаатарын Их Сургууль, Монгол улс |
| Анархааны Маратхаан | (Археологич) Улаанбаатарын Их Сургууль, Монгол улс |
| Пак Жин ху | Боловсролын Удирдлагын Их Сургууль, Солонгос улс, магистрант |

Ким Ён соб

(Археологич) Боловсролын Удирдлагын Их Сургууль,
Солонгос улс

Ирү Квон

Боловсролын Удирдлагын Их Сургууль, Солонгос улс,
магистрант

Туслах ажилчдаар:

1. Д.Шинэсаран (УБИС-ийн магистрант)
2. Д.Отгон (УБИС-ийн магистрант)
3. З.Болортуяа (УБИС-ийн магистрант)
4. Ц.Галбадрах (УБИС-ийн НУФ-ийн Археологи IV анги)
5. Нандин-Эрдэнэ (УБИС-ийн НУФ-ийн Археологи IV анги)
6. Ж.Эрдэнэ (УБИС-ийн НУФ-ийн Археологи III анги)
7. Г.Батхүү (УБИС-ийн НУФ-ийн Археологи III анги)
8. Г.Энхмагнай (УБИС-ийн НУФ-ийн Археологи III анги)
9. А.Мөнгөншагай (УБИС-ийн НУФ-ийн Археологи III анги)
10. Б.Өнөрбаяр (УБИС-ийн НУФ-ийн Археологи III анги)
11. А.Дамдинсүрэн (УБИС-ийн НУФ-ийн Археологи II анги)
12. Г.Дэлгэрмөрөн (УБИС-ийн ХЗФ-ийн Хятад хэлний II анги)

Жолооч нар

- | | | |
|-------------------|-----------|-------------------|
| 1. Д.Чулуунбаатар | УБВ 41-36 | ГАЗ 66 |
| 2. Д.Чулуун | УБЗ 22-20 | Land 80 |
| 3. Д.Отгонбаатар | УБЯ 64-15 | Mitsubishi Pajero |
| 4. Д.Даваажаргал | УБХ 60-68 | Mitsubishi Delica |
| 5. Ч.Жаргалсайхан | УБЧ 57-09 | Mitsubishi Delica |

Тогооч

Д.Пүрэвсүрэн

Судалгааны ажлын үнээ хэсэг, маршрут, санхүүжилт Тус хээрийн шинжилгээний анги нь Улаанбаатар хот – Хэнтий аймгийн төв Өндөрхаан хот – Сүхбаатар аймгийн Мөнххаан сум – Баруун-Урт хот – Дарьганга сумын Гүн хонхор, Вааран хавцал гэсэн маршрутаар, МИЦУБИШИ ДЕЛИКА, МИЦУБИШИ ПАЖЕРО, ГАЗ 66, ЛАНД 80 маркийн машинуудаар явах

болно. Судалгааны ажлын бүх үр дүнгийг Солонгос улсын Боловсролын Удирдлагын Их Сургуулийн 2010 оны 07-р сарын 09-ноос 07-р сарын 23-ны өдрийг хүртэл Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутгаар археологийн хайгуул судалгаа болон Гүн хонхор, Вааран хавцал хэмээх газарт археологийн малтлага судалгааны ажил хийж гүйцэтгэнэ.

Ажлын хөтөлбөрийг боловсруулсан

Доктор (Ph), профессор Д.Эрдэнэбаатар

Монголын улсын Улаанбаатарын Их Сургууль болон Солонгос улсын Дангүүгийн Их Сургуулийн Умардын Соёлын хүрээлэн, Боловсролын Их Сургууль 2008 оноос хамтран ажиллах шийдвэрийг гарган 2009 оны 4-р сарын 27-нд Улаанбаатар хотод “Дорнод Монгол ба Умардын соёл” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулсан бөгөөд уг хуралд Монгол, Солонгос, Украин, ОХУ, Казахстан улсын эрдэмтэн судлаачид оролцон сонирхолтой илтгэлүүдийг хэлэлцүүлсэн юм.

Хурлын зорилго Монгол орны дорнод хэсгийн эртний түүх соёлын дурсгалууд Хятадын зүүн хойд, хойд болон Солонгосын баруун хойд бүсийн археологийн дурсгалуудтай түүх соёлын ямар нэгэн уялдаа холбоо байгаа эсэхийг тодруулах явдал байсан юм.

Уг хурлын маргааш буюу 4-р сарын 28-аас 5-р сарын 4-ний хооронд хуралд оролцсон эрдэмтэдийг Хэнтий, Сүхбаатар аймгийн нутгаар дагуулан явж эртний түүх соёлын дурсгалт газрууд болон түүхийн биет дурсгалуудыг үзүүлэх, мөн ирэх жил археологийн малтлага судалгаа явуулах дурсгалаа сонгов.

Улмаар оны 8 сарын 20-ноос 8-р сарын 31-ний хооронд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Вааран хавцал хэмээх газарт Хүрэл зэвсгийн үеийн томоохон цогцолбор дурсгалыг шинээр нээн илрүүлж, тэдгээрээс нэг дөрвөлжин булш, нэгэн тахилын байгууламжийг малтан судласан билээ. Мөн малтлагын явцад Вааран хавцалын зүүн талын дэнж дээрх дурсгалуудын дэвсгэр зургийг үйлдэн баримтжуулсан юм [Эрдэнэбаатар нар, 2009].

Харин энэ жил бид Дарьганга сумын төвөөс хойш 9 км-т байрлах Гүн хонхор хэмээх газрын арын дэнжид нэгэн том хэмжээтэй тахилгын байгууламж, Вааран хавцалд 3 шоргоолжин булш малтан судалсан бөгөөд мөн малтлагын хажуугаар бэсрэг хайгуулын ажлыг хийж гүйцэтгэв.

Бид малтлага болон хайгуул судалгааг хоёр бүлэг болгон доор сийрүүлэн бичив.

МАЛТЛАГА СУДАЛГАА

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвөөс зүүн хойш 9 орчим километр зайд Гүн хонхор хэмээх газрын арын дэнжид дугуй хүрээтэй, голдоо чулуун дараасгүй, гурван том чулуун байгууламж бий [Эрдэнэбаатар нар, 2009]. Бид энэхүү байгууламжийг 2009 оны хавар хайгуулын явцад шинээр олж илрүүлсэн бөгөөд мөн үүнтэй төстэй боловч хэмжээгээр арай жижиг байгууламжийг Тоорой бандийн хөшөөний зүүн хойд талд Гангын хар овоо хэмээх газарт байсныг хэмжилт хийн баримтжуулсан болно.

Гүн хонхор. Гүн хонхорын арын дэнжид гурван ðàðëëüí байгууламж áàéò á°ãªªá òýääýúðëēā áèā āāðóóí òàēāñ īū yōēýí áõāāðēāæ ôîēī äýâñäýð çòðāā ¿ēēäýā. Äýâñäýð çòðāā ¿ēēäýñîēē āāðāāāāāð òàìæēí āāðóóí òàēüí àēäíēé¹⁰¹ õýíýýí áõāāðēāñāí òàðëëüí áàēáóóēàìæēí ìàēòāí ñóāäēēāà.




Энэ нь 23 х 26 м хэмжээтэй дугуй хүрээтэй, голдоо хэд хэдэн жижиг чулуун овоолго бүхий байгууламж байсан бөгөөд өнгөн хөрсийг цэвэрлэхдээ хойноос урагш, зүүнээс баруунш 30 см өргөн хөндлөн огтлолын хамар үлдсэн 5-20 см гүнтэйгээр доош үйлдэв. Цэвэрлэгээ хийсний дараа олон талаас нь гэрэл зураг авч дурсгалын гар зургийг хийв. Бүх баримтжуулалт дууссаны дараагаар хөндөлөн огтлолын хойноос урагш татсан хамрын баруун, зүүн талын хэсгээр хэд хэдэн жижиг чулуун овоолго илэрсэнийг доош шалган сорилтын малтлага хийсэн боловч ямар нэгэн зүйл илэрсэнгүй. Мөн дурсгалын төв хэсэг болон дурсгалын баруун талын зүйн талын байгалийн хөрснөөс арай ялгарсан улбар шаргал болон хүрэн бор өнгийн толбонуудын доош сорилтын малтлага хийсэн боловч олдвор болох зүйл илэрээгүй багалийн эх шороо гарсан тул малтлагыг зогсов (Зураг 01-07). Байгууламжаас зүүн тийш 100 м орчимд мөн жижиг чулуун

байгууламж байх бөгөөд сорилтын малтлага хийхэд ямар нэгэн зан үйлийн холбогдолтой зүйл илэрсэнгүй (Зураг 08).



Зураг 01-02. Гүн хонхорын тахилын байгууламжийн цэвэрлэгээний өмнөх ба дараахи ерөнхий байдал





Зураг 03-04. Байгууламжийн хөндлөн огтлолын баруун талын жижиг чулуун овоолго



Зураг 05-06. Байгууламжийн хөндлөн огтлолын баруун, зүүн талын жижиг чулуун овоолго




Зураг 07-08. Байгууламжийн зүүн талын хүрээ чулуу, байгууламжаас зүүн тийш 100 м орчимд зайд байсан жижиг чулуун байгууламж


Вааран хавцал. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Вааран хавцал хэмээх газар бид 2009 онд хоёр булш малтсан бөгөөд энэ жил гурван шоргоолжин булшийг нэмэн малтлаа. Энэхүү гурван булшийг бид хойноос урагш 3,4,5-р булш хэмээн дугаарласан болно. Мөн малтлагын явцад эдгээр гурван булшны эргэн тойрон дахь булшуудын дэвсгэр зургийг дахин үйлдэж баримтжууллаа. Энэ хавийн шоргоолжин булшнууд хэмжээний хувьд харилцан адилгүй бөгөөд хамгийн том нь 7,5 х 20,6 м байхад хамгийн жижиг нь 1,9 х 3,3 м байв. Бид нийт 37 булшийг баримтжуулан дэвсгэр зургийг үйлдэх явцад гурван шоргоолжин булшнаас зүүн хойш цуварсан зэл чулуутай байлаа.




A photograph of a large, rectangular stone structure, likely a tomb or altar, partially buried in a dry, dusty landscape. The structure is made of rough-hewn stones and is surrounded by a low wall. A red and white striped pole is leaning against the structure for scale.



4-р булш. 3-р булштай адилханаар хавтгай нимгэн чулуугаар өрлөг хийж, гадна талаас нимгэн чулуугаар хашсан байдалтай бөгөөд булшны зүүн талын хананаас үргэлжилсэн чулуун овоолго байна. Булшны өрлөгийн урт гадна ханандаа 4.2 м, дотор ханандаа 4 м, өргөн гадна ханандаа 3.4 м, дотор ханандаа 2.6 м байв. Булшийг өнгөн хөрсний цэвэрлэгээний дараа доош 30 см гүнтэйгээр малтан судлахад ямар нэгэн нүхний толбо мэдэгдсэнгүй, эх газрын шороо илэрлээ.




5-р булш. Булшийг үйлдэхдээ нимгэн хавтгай чулууг хавиргалан босгож хүрээлсэн бөгөөд баруун талд нь том чулууг босгожээ. Булшны өрлөгийн урт гадна ханандаа 3.6 м, дотор ханандаа 2.6 м, өргөн гадна ханандаа 2.4 м, дотор ханандаа 2 м байв. Булшны өнгөн хөрсний цэвэрлэгээний дараа доош үргэлжлүүлэн 20-30 см гүнтэйгээр малтан судлахад ямар нэгэн нүхний толбо илэрсэнгүй байгалийн үндсэн хөрс гарав.



ХАЙГУУЛ СУДАЛГАА

Бид малтлага судалгааны ажлын хажуугаар энэ бүс нутагт археологийн хайгуул судалгааг явуулсан болно. Хайгуул судалгааг нутгийн уугуул иргэн Д.Дугарсүрэн хэмээх өмнө нь тус сумын засаг дарга, тусгай хамгаалалттай газрын дарга зэрэг алба хашиж байсан хөгшинтэй уулзан ярилцаад газарчлуулахаар тохиролцож судалгааг хийлээ. Судалгааны явцад шинэ чулуун зэвсгийн үеийн олон тооны чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булш, шоргоолжин булш, түрэгийн тахилын онгон зэрэг археологийн дурсгалуудыг нээн илрүүлэв. Мөн иргэн Д.Дугарсүрэн гуайн цуглуулсан чулуун зэвсгийн олдворууд, ваар савны хагархай зэргийг баримтжуулан авсан болно. Хайгуулаар илрэн олдсон дурсгалуудыг доор сийрүүлэн бичвэл,



Эрэн хошуу. Биднийг малтлага хийж байх үед нутгийн иргэд ирж археологийн ажлын талаар сонирхон асуух, зарим нэгэн хүмүүс эрс эсэргүүцэх зэрэг асуудал гарч байсан юм. Бид эсэргүүцэж байгаа хүмүүс үнэн зөв мэдээллийг ярьж ойлгуулах, эртний түүх, археологийн малтлага болон хайгуулын ажлын ач холбогдолын талаар тодорхой мэдээлэл өгч байв. Энэ үеэр нутгийн залуус болон настай хүмүүсээс энэ бүс нутагт археологийн дурсгал бий эсэх байвал хаана байгаа зэрэг мэдээллийг асуун цуглуулсан болно. Тэдгээр мэдээллийн дотор бараг хүн бүр Эрэн хошуунд маш их булш бий гэгцгээж байлаа. Тиймээс энэ мэдээллийг шалгах сонирхол их төрж байв.



Сумын төвөөс баруун хойш 10 орчим км-т Эрээн хошуу хэмээх зүүн хойноос баруун урагш сунаж тогтсон намхан нурууны дээд талын тэгш дэвсгээр байгалийн ургаа хад бүхий тогтоцууд бий. Тэдгээр тогтоцын дунд хэсэгт 31 х 29.5 м голчтой бүхий цагирган тахилын байгууламж бий. Үүнтэй ижилхэн хэмжээ, хэлбэртэй байгууламж энэ бүс нутгаар цөөнгүй байх бөгөөд тэдгээрээс Гүн хонхор хэмээх газарт 3 ширхэг байгаас нэгийг сонгон малтан судалсан боловч ямар нэгэн эд өлгийн зүйлс илрээгүй билээ. GPS: 1186 м, 45° 26' 17,5" 113° 41' 47,1"


Рашаант. Сумын төвөөс баруун хойш 7,5 орчимд Рашаант эх хэмээх олон өнгийн рашаан ус гардаг хойноо жижиг толгойтой байгалийн өвөрмөц тогтоц газар бий. Энэхүү олон өнгийн рашааны эхийн зүүн хойд талын толгойн өвөрт Рашаантын хийдийн турь бий. Бид олон өнгийн рашаанаас амсаад хайгуулаа цааш үргэлжлүүлэв. GPS: 1128 м, 45° 21' 39,0" 113° 43' 01,0"



Уулзварын гол. Дээрх дурсгалаас баруун хойш 4 км орчимд Уулзварын голын доод адагт голын зүүн талын уулын бэл, оройн дэвсгэ дээгүүр 20 орчим дөрвөлжин булш, 5-7 ширхэг жижиг дугуй дараастай булш бий. Дөрвөлжин булшнууд нь дөрвөн буландаа босоо хөшөөтэй болон жигд намхан хашлагатай 3 х 2 м-с 6 х 4 м хэмжээтэй байв. GPS: 1106 м, 45° 23' 53,2" 113° 37' 16,5"



Хөдлөнгийн гол. Голын ар талын тэгш дэнж дээр зэрэгцээ байрлах 10 түрэг тахилын онгон бий. Тахилын онгоноос баруун хойш 295 метр зайд 290 градуст зэл чулуу хоёр эгнээгээр цувруулан үйлджээ. Тахилын онгоны хойд талд нэг ширхэг дөрвөлжин булш байв. GPS: 1053 м, 45° 22' 44,9" 113° 26' 06,7"





Нам ухаа. Дээрхи дурсгалаас баруунш Хөндлөнгийн голын хойд талаар үргэлжлэх алсаасаа өрдөрсөн жижиг дэвсгийг “Нам ухаа” хэмээн нутгийн иргэд нэрлэдэг ажээ. Энэхүү өндөрлөг дэнж газарт энд тэндгүй хонхойлгон ухсан элсэн карер байх бөгөөд карерын хонхор

болон түүний эргэн тойрноос шинэ чулуун зэвсгийн үед холбогдох жижиг жижиг чулуун зэвсгүүд буйг анх нутгийн иргэн Д.Дугарсүрэн үзэж зарим нэгэн чулуун зэвсгийг түүвэрлэн авсан байв. Биднийг очиж үзэхэд 100 м орчим талбайд шинэ чулуун зэвсгийн үед холбогдох чулуун зэвсгүүд тарсан байсан бөгөөд бид тухайн газраас зарим нэгэн чулуун зэвсгийг түүвэрлэн авч баримтжуулсны дотор чулуун зуулга ир, ялтас залтас, маш олон тооны янз бүрийн өнгийн үлдэц, бэлдэцүүд, чулуун зүү зэрэг байлаа.



Иргэн Д.Дугарсүрэн энэхүү газраас өмнө нь маш олон тооны бэлдэц, үлдэц, зуулга ир, залтас, ялтас, үр тариа цайруулах самбар чулуу, нухуур, нүдүүр, чулуун жадны хугархай зэргийг түүвэрлэн авснаа хайгуулын ажил дууссаны дараа бидэнд үзүүлсэн юм. Бидэнд үзүүлсэн олдворууд нь хийцийн хувьд маш нарийн бөгөөд зэвсгүүд томоосоо жижиг олон янзийн олон төрөл байлаа. Иргэн Д.Дугарсүрэн нь эртний түүх соёлын дурсгалыг хайрлан хамгаалах, бүртгэн тэмдэглэх ажлыг орон нутагтаа хийж байсан бөгөөд ийнхүү судалгаа хийж мэргэжлийн хүмүүс удаа дараа тайлагнаж байжээ. Судалгааны явцад чулуун зэвсгийн бууц суурин газраас өөрийн сонирголоороо эд өлгийн зүйлс цуглуулж өөрийн хувийн цуглуулгатай болжээ. Бид цуглуулсан олдворуудыг нь үзэж сонирхон гэрэл зургийг нь авч баримтжуулсан юм. GPS: 1049 м, 45° 22' 53,2" 113° 24' 38,0"





Мөн энэхүү шинэ чулуун зэвсгийн бууц суурингийн эргэн тойронд 10 орчим дөрвөлжин булш, зэл чулуутай 10 орчим шоргоолжин булш байв. Зэл чулууд нь зүүн хойноос баруун урагш, баруун урдаас зүүн хойш цуварсан бйдалтай байлаа. GPS: 1053 м, 45° 22' 58,2" 113° 24' 37,8"



Дээрхээс зүүн урагш 300 м орчимд Хөдлөнгийн голын ар талын гол руу түрж орсон хошууны үерийн усанд идэгдсэн элстэй эргийн эргэн тойронд хөх саарал өнгийн ваар савны хагархай ихээр олдож байв. Энэ нь магадгүй үерийн усаар энд хөвж ирсэн бололтой учир нь бид түүний ойр орчим маш сайн хайж үзсэн ч өөр ямар ч эд өлөг, булш, суурингийн зүйлс илрээгүй юм. GPS: 1044 м, 45° 22' 33,2" 113° 25' 42,2"



Биднийг энэ бүс нутагт хайгуул хийж байх үед цаг орой болсон учир бид хайгуулаа үргэлжлүүлэх боломжгүй болж малтлага хийж буй лагерын зүг хөдөллөө.